



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Баян-Өлгий аймгийн "СУАТ" ХХК-ийн
цэвэр, бохир усны үйлчилгээний тариф
батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий аймгийн "СУАТ" ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг "СУАТ" ХХК /С.Нурбек/-д үүрэг болгосугай.

3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "СУАТ" ХХК /С.Нурбек/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2017 оны 85 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, 2021 оны 67 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, Зохицуулах хорооны 2023 оны 87 дугаар тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

142510281

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн 132 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

᠑᠖᠒᠒᠔᠑᠐᠓᠑4
᠓᠙33547 5611᠑47


**Баян-Өлгий аймгийн “СУАТ” ХХК-ийн
цэвэр, бохир усны үйлчилгээний тариф**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	1.86
	Тоолуургүй	төг/л	2.08
Бохир ус	Тоолууртай	төг/л	1.86
	Тоолуургүй	төг/л	2.08

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	6.5
	Төсөвт байгууллага	төг/л	8.8
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	6.8
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, эмнэлэг	төг/л	7.2
Бохир ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	6.9
	Төсөвт байгууллага	төг/л	9.6
	Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	7.2
	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, эмнэлэг	төг/л	7.9
	Зөөврөөр	төг/л	35.0



**Баян-Өлгий аймгийн "СУАТ" ХХК-ийн
цэвэр, бохир усны үйлчилгээний суурь хураамж**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	2,250	750

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	5,400	1,500
2.	20	7,440	1,800
3.	25	11,400	2,700
4.	32	16,800	4,050
5.	40	25,080	6,000
6.	50	38,520	9,600
7.	65	48,960	11,850
8.	80	66,360	15,750
9.	100	98,400	22,920
11.	150	156,600	37,800
15.	400=<	576,000	115,200

--- о О о ---